



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2018 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 4/515

Улаанбаатар хот

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нөхөн олговортой нислэг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Г.Батбаяр	Агаарын тээврийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Г.Бат-Алдар	Худалдан авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн
Гишүүд:	Д.Одгэрэл	Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албаны Аюулгүй ажиллагааны хэсгийн дарга
	Б.Ганцогт	Үйлдвэрчний эвлэлийн хорооны төлөөлөл
	Ё.Ганбат	Монголын нислэгийн удирдагчдын холбооны гишүүн

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо /Г.Батбаяр/-нд даалгасугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, Тендер нээхэд үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Г.Бат-Алдар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН